

Аймгийн Засаг даргын 2022 оны
02 сарын 10 -ны өдрийн 1/88 дүгээр
захирамжийн нэгдүгээр хавсралт

“ЦЭВЭР ОРЧИН-ЦЭМЦГЭР БУЛГАН” АЯНЫ УДИРДАМЖ

Нэг. Аяны зорилго

“Байгаль орчныг хамгаалах тухай” хууль, “Хог хаягдлын тухай” хууль, аймгийн Засаг даргын “Шинэ хөгжлийн зам” мөрийн хөтөлбөрийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх, иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх, хог хаягдлыг багасгах, орчны бохирдол доройтлыг бууруулах ажлыг зохион байгуулж, хоггүй цэвэр сайхан орчныг бүрдүүлэхэд оршино.

Хоёр. Хамрах хүрээ

Аймгийн хэмжээнд сум, баг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага

Гурав. Хэрэгжүүлэх хугацаа

Аймгийн хэмжээнд “Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аяныг 2022 оны 02 дугаар сарын 10-ны өдрөөс 12 дугаар сарын 10-ны өдрийг дуустал зохион байгуулна.

Дөрөв. Аяны үйл ажиллагааны чиглэл

Аяныг хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах, сургалт сурталчилгаа зохион байгуулах, болзолт уралдаан зарлах, хариуцлагын тогтолцоог хэвшүүлэх гэсэн чиглэлээр зохион байгуулна.

Нэгдүгээр чиглэл: Хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах

1. Төв суурин газарт нийтийн эзэмшлийн талбай, айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах

2. Сум, багуудад өвөлжөө, хаваржаа, бэлчээр, гол горхи, нуур цөөрмийн хог хаягдал, үхсэн малын сэг зэмийг цэвэрлэх /Сэг зэмийг устгах ажлыг сумын Мал эмнэлгийн газар хариуцан хийж гүйцэтгэх/

3. Улсын болон орон нутгийн чанартай авто зам, уул даваа, овоо тахилгын хог хаягдлыг цэвэрлэх

4. Эзэнгүй хог хаягдал, хууль бус хогийн цэгүүдийг цэвэрлэх, дарж булах

5. Аймгийн баяр наадмын өмнө, хойно нийтийг хамарсан цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах

Хоёрдугаар чиглэл: Сургалт сурталчилгаа

1. Аяныг олон нийтийг хамруулсан өдөрлөг, сурталчилгааны ажил зохион байгуулах

2. Хог хаягдлын тухай хууль, хог хаягдлыг багасгах, ангилан ялгах, эргүүлэн ашиглах, гялгар уутны хэрэглээнээс татгалзах талаар сургалт зохион байгуулж, сурталчилгаа хийх

3. Сумдад хүүхэд залуучуудад экологийн боловсрол олгох ажлыг зохион байгуулсан байх

Гуравдугаар чиглэл: Хариуцлагын тогтолцоог хэвшүүлэх

1. Хог хаягдалтай холбоотой зөрчлийг шийдвэрлэх ажлыг иргэд байгууллагуудад ойлгуулан таниулах ажлыг сум бүр зохион байгуулах /Сум, багийн Засаг дарга, Цагдаа, Мэргэжлийн хяналтын байцаагч хариуцан гүйцэтгэх/

2. Олон нийтийн байцаагч ажиллуулж, ил задгай, зориулалтын бус газар хог хаягдал хаях, шатаах зөрчлүүдэд тогтмол хяналт тавих

3. Хариуцлагын тогтолцоог хэвшүүлэх, сум, багийн Засаг дарга, цагдаа, мэргэжлийн хяналтын байцаагчдын зөрчил гаргагчдад оногдуулах торгууль, шийтгэврийн ажлыг эрчимжүүлэх

Тав. “Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аяныг дүгнэх

1. Сумдыг аяны хүрээнд зохион байгуулсан ажлаар нь дүгнэн байр эзлүүлнэ.

2. Аяны хүрээнд зохион байгуулсан ажлыг дүгнэхдээ зохион байгуулсан ажлын үр дүн, чанар, аж ахуйн нэгж, албан байгууллага, иргэд, аялал жуулчлалын аж ахуйн нэгж байгууллагыг татан оролцуулсан байдал зэргийг харгалзан үзнэ.



Аймгийн Засаг даргын 2022 оны
сарын 19-ны өдрийн 28 дүгээр
захирамжийн 2 дугаар хавсралт

“ЦЭВЭР ОРЧИН-ЦЭМЦГЭР БУЛГАН” АЯНЫ ХҮРЭЭНД ХОГ ХАЯГДЛЫГ БАГАСГАХ ТАЛААР ХЭРЭГЖҮҮЛЭХ
АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ /2022 ОН/

№	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний төлөвлөгөө	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэгч	Санхүүжих эх үүсвэр (сая.төг)	Хүрэх үр дүн
1. Удирдлага зохион байгуулалт, хамтын ажиллагааны чиглэлээр							
1.1	2022 онд хог хаягдлын талаар хийх ажлын төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэх	1.1.1. Хог хаягдлын талаар 2022 онд хийгдэх ажлыг сумын Засаг дарга нар болон холбогдох мэргэжилтнүүдэд танилцуулан, хэлэлцүүлэх 1.1.2. Жилийн ажлын төлөвлөгөөг сумын Засаг дарга нар, байгууллагын дарга нарт хүргүүлж, хэрэгжилтийг хангуулах	I/05 II/07-10	БОАЖГ ХОХБТХ	ХОХБТХ БОАЖГ	Үйл ажиллагаагаар Үйл ажиллагаагаар	Ажлын төлөвлөгөөг нарийвчлан гаргана. Хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах ажлыг төлөвлөгөөний дагуу зохион байгуулна. Хог хаягдлын асуудлыг шат дараатай шийдвэрлэх төлөвлөгөөтэй болно.
1.2	Хог хаягдлын менежментийн мастер төлөвлөгөөг боловсруулах	1.2.1. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний төслийг Мэргэжлийн байгууллагатай хамтран боловсруулж аймгийн Засаг даргын зөвлөл, ИТХ-д танилцуулан батлуулах	I-II улирал	БОАЖГ	Булган сумын ТУА	Үйл ажиллагаагаар	Хог хаягдлын асуудлыг шат дараатай шийдвэрлэх төлөвлөгөөтэй болно.
1.3	“Цэвэр орчин-Булган” хүрээнд бүх нийтийн цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах	1.3.1. Хаврын цэвэрлэгээний ажлыг 2 сарын хугацаатай, баяр наадмын үеийн цэвэрлэгээг 2 удаа, намрын цэвэрлэгээг 2 удаа зохион байгуулах.	IV/05-VI/05, VII/04-VII/15 VIII/10-15 IX/26-30	БОАЖГ	СЗДТГ	34.0	Аймгийн хэмжээнд хатуу хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах ажил хийгдэнэ.
1.4	Хог хаягдлын хуулийн дагуу үйлдвэрлэгч болон импортлогч нь бүтээгдэхүүний	1.4.1. Компаниудад сав баглаа боодлоо эргүүлэн татах талаар аймгийн Засаг даргын албан бичгийг хүргүүлж, хэрэгжүүлэн ажиллах /АПУ, ... г.м/	II/14-18	БОАЖГ	СЗДТГ	Үйл ажиллагаагаар	Хог хаягдлын хуулийн хэрэгжилт хангагдаж, хог хаягдлын цэгт хүргэх хог хаягдлын

	бүтээгдэхүүний хаядал, тэдгээрийн сав, баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн ашиглах, дахин боловсруулах, ажлыг зохион байгуулах	1.4.2.Компаниудын гэрээт борлуулагч нартай сав баглаа боодлоо эргүүлэн татах гэрээ байгуулах	I улирал	СЗДТГ	БОАЖГ	Үйл ажиллагаагаар	хэмжээ багасна.
1.5	Шатахуун түгээх станцуудтай гэрээ байгуулан ажиллах	1.5.1.Шатахуун түгээх станцуудын дэргэд хогийн сав байрлуулах ажлыг зохион байгуулах 1.5.2.Хогийн савны хог хаягдлыг ачиж зайлуулах ажлыг зохион байгуулах	Жилдээ	СЗДТГ	ААНБ, ШТС	ААНБ-ын хөрөнгө	Зорчин явагчид хог хаягдлаа хийх цэгтэй болж, эзэнгүй хог хаягдал багасна. Сумын ЗДТГ-тай гэрээ байгуулан хог хаягдлыг ачиж тээвэрлэнэ.
1.6	Орхон аймагтай гэрээ байгуулан ажиллах	1.6.1.Хил залгаа сумдын нутаг дэвсгэрийн хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах ажлыг хамтран зохион байгуулах	V-VI сар	Булган, Орхон аймгийн ЗДТГ, БОАЖГ	СЗДТГ	ОНТ	Хил залгаа нутаг дэвсгэрийн хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулна.
1.7.	Хог хаягдлын талаар хийсэн ажлын тайланг нэгтгэх, дүгнэх	1.7.1.Сумдыг зохион байгуулсан ажлаар нь дүгнэн байр эзлүүлнэ. 1.7.2.Хог хаягдлын талаар хийсэн ажлын тайланг сумдаас хагас, бүтэн жилээр авч нэгтгэн аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулах	XI/10-15	БОАЖГ	СЗДТГ	Үйл ажиллагаагаар	Сумын Засаг даргын ажлын гол үзүүлэлт болгон дүгнэнэ.
2.1	Аймгийн хэмжээнд "Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аян, хог хаягдлыг	2.1.1.Олон нийтийн ТВ-ээр "Цэвэр орчин-Цэмцгэр Булган" аян, аяны хүрээнд зохион байгуулж байгаа ажлын талаар мэдээлэх	Жилд 4 удаа	ХМОНХА	БОАЖГ	ОНТ	Жилийн ажлын дүнг дүгнэнэ. Зохион байгуулж байгаа үйл ажиллагааг улсын хэмжээнд сурталчилна.
2.Мэдээ мэдээлэл, сургалт сурталчилгааны ажлыг зохион байгуулах талаар							

	багасах, цэвэрлэх ажлыг сурталчлан таниулах ажлыг зохион байгуулах	2.1.2.Орон нутгийн ТВ-ээр хог хаягдлыг багасах, ангилан ялгах талаар сурталчлах	Сард 2-оос доошгүй	БОАЖГ	СЗДТГ, ТУА, Сайхан Монгол ТВ	ОНТ	Иргэд олон нийтэд мэдээлэл түгээнэ.
2.2	Цахим орчин, олон нутгийн сүлжээгээр сурталчлан таниулах	2.1.3.Аялал жуулчлалын ААНБ-ууд амрагч, жуулчдад хог хаягдлыг багасах талаар сурталчилгаа хийх	V/01-IX/01	ААНБ	БОАЖГ, СЗДТГ	Үйл ажиллагаагаар	Амрагч, жуулчдад мэдээлэл түгээнэ.
		2.2.1.Хог хаягдлыг ангилан ялгах, эргүүлэн ашиглах талаар шторк хийж цахим орчноор сурталчлах	Жилийн турш	БОАЖГ	СЗДТГ, ААНБ	Үйл ажиллагаагаар	Иргэд хог хаягдлыг багасах, ангилан ялгах талаар тодорхой мэдлэгтэй болно.
2.3	Сургалт зохион байгуулах	2.2.2.Хог хаягдлыг багасах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлыг олон нийтэд түгээх, танилцуулах	Жилийн турш	АЗДТГ-ын ХМОНХА, БОАЖГ	СЗДТГ, ААНБ	Үйл ажиллагаагаар	Иргэд мэдээллээр хангагдана.
		2.3.1. Каритас Чех Репаблик, Монголын тогтвортой хөгжлийн гүүр, Монголын байгаль орчин, аюулгүй байдлыг төвөөс хамтран хэрэгжүүлж байгаа "Монгол улс дахь хуванцар хог хаягдлын дахин боловсруулалтын тогтвортой байдлыг хангах" төсөлтэй хамтран сургалт зохион байгуулах	I-IV улиралд	БОАЖГ	Каритас Чех Репаблик, Монголын тогтвортой хөгжлийн гүүр, Монголын байгаль орчин, аюулгүй байдлыг төв	Үйл ажиллагаагаар	Иргэд мэдээллээр хангагдана.
		2.3.2.Булган сумын 6 багт хог хаягдлыг ангилан ялгах талаар сургалт мэдээлэл хийх	III/14-IV/25	СЗДТГ, ТУА	БОАЖГ	Үйл ажиллагаагаар	Иргэд хог хаягдлыг багасах, ангилан ялгах талаар тодорхой мэдлэгтэй болно.
		2.3.3.Сумдад сургалт, мэдээллийн ажлыг зохион байгуулах /Тамгын газрын ажилтнууд, ААНБ-ын дарга нар, багийн Засаг дага нарыг хамруулна/	III/01-25	БОАЖГ	СЗДТГ	ОНТ	Сумын багийн Засаг дарга, иргэдэд хог хаягдлын талаар сургалт зохион байгуулж, аяны үйл ажиллагааг сурталчилна.
	2.3.4.Уул уурхайн ААНБ-уудад хог хаягдлын талаар сургалт зохион	V/02-30	БОАЖГ СЗДТГ	ААНБ	ОНТ	Иргэд хог хаягдлыг багасах, ангилан	

	байгуулах					ялгах талаар тодорхой мэдлэгтэй болно
"Цэвэр Цэмцгэр Булган" аяныг зохион байгуулах	<p align="center">3.Орчны доройтлыг бууруулж, эрүүл ахуйг сайжруулах үйл ажиллагаа</p> <p>3.1.1.Сумын Засаг дарга, багийн Засаг даргын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хогийн савны ашиглалтыг сайжруулах заалтыг тусган хэрэгжүүлэх</p> <p>3.1.2.Булган сумын багуудын хооронд хог хаягдлыг хамгийн сайн ангилан ялгасан баг шалгаруулах уралдаан зарлах</p> <p>3.1.3.Булган сум ангилсан хогийг ачих хуваарь гарган тусд нь тээвэрлэх</p> <p>3.1.4.ТУА-д олгосон хог хаягдал преслэгчийг ашиглалтад оруулах</p> <p>3.1.5.Хог ангилан ялгах цехийн түрээслэгчтэй үйл ажиллагааг сайжруулах гэрээ байгуулж үүрэг хариуцлагыг дээшлүүлэх</p> <p>3.1.6.Булган сумын нийтийн эзэмшлийн талбай, орон сууцны гаднах хогийн савыг засварлаж, өнгө үзэмжийг сайжруулах</p> <p>3.1.7.Сумын төвийн хогийн савыг нэмэгдүүлэх арга хэмжээг зохион байгуулах</p> <p>3.1.8.Сумд хог хаягдлыг ангилан ялгах ажлыг зохион байгуулж, ангилсан хог</p>	I-VI сар	БОАЖГ	Сумын Засаг дарга, багийн Засаг дарга	Үйл ажиллагаагаар	Хогийн савны ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулна.
		I-VI сар	СЗДТГ	Багийн Засаг дарга, ААНБ, иргэд	Сумын төсөв	Хогийн савны ашиглалтыг сайжирч, иргэд хог хаягдлаа ангилан ялгаж хэвшинэ.
		Сард 1 удаа	СЗДТГ, ТУА	Иргэд, ААНБ	Үйл ажиллагаагаар	Дахин ашиглагдах хог хаягдлын нөөц бүрдэнэ.
		Сард нэг удаа преслэх	ТУА	СЗДТГ	Үйл ажиллагаагаар	Дахин ашиглагдах хог хаягдлын нөөцтэй болж, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бэлдэц хийх боломж бүрдэнэ.
		11/14-22	БОАЖГ	Булган сумын ЗДТГ, ТУА	Үйл ажиллагаагаар	Ангилсан хогийг бэлдэц болон эцсийн бүтээгдэхүүн болгох үйл ажиллагаа сайжирна.
		IV/05-VI/05	СЗДГ, ТУА	ААНБ	Үйл ажиллагаагаар	Хогийн савны насжилт сайжирч, өнгө үзэмж нэмэгдэнэ.
		I-VI сар	СЗДТГ	ААНБ	Сумын төсөв, ААНБ-ын хөрөнгө	Стандартын шаардлага хангасан хогийн савтай болж, эзэнгүй хог хаягдал багасна.
		Жилдээ	СЗДТГ	ААНБ, иргэд	Үйл ажиллагаагаар	Хог хаягдлыг ангилан ялгах

	хаягдлыг хүлээн авах цэгтэй болох						болмж бүрдэж, байгальд хаягдах хог хаягдлын хэмжээ багасна.
	3.1.9.Ангилсан хог хаягдлыг тушаах газартай гэрээ байгуулан тогтсон хугацаанд ачиж тээвэрлэх ажлыг зохион байгуулах	Жилдээ	СЗДТГ	ААНБ, иргэд	Үйл ажиллагаагаар	Ангилсан хог хаягдлыг дахин ашиглах боломж бүрдэнэ.	
	3.1.10.Хаврын бүх нийтийн цэвэрлэгээний ажлыг зохион байгуулан айл өрх, ААНБ өөрийн эзэмшил газрын хог хаягдлыг цэвэрлэн зайлуулж, хашаа, байрныхаа өнгө үзэмжийг сайжруулах	IV/05-VI/05	БОАЖГ	СЗДТГ, ААНБ	ОНТ	Хатуу хог хаягдлыг цэвэрлэн зайлуулж, орчны бохирдол багасна.	
	3.1.11.Гол горхи, рашаан ус, нуур цөөрөм, уст цэгүүдийн орчны хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах	IV/05-VI/25	СЗДТГ, ААНБ	Иргэд	ОНТ	Уст цэгүүдийн бохирдлыг багасгаж, бохирдлоос урьдчилан сэргийлнэ	
	3.1.12.Хог хаягдлыг багасгах, ангилан ялгах, дахин ашиглах талаар шинэ санаачлага, гарган хэрэгжүүлэх	IV/05-VI/05	СЗДТГ	ААНБ, иргэд	Үйл ажиллагаа, сумын төсөв	Олон нийтэд түгээн дэлгэрүүлхүйц шинэ санаа санаачлага бүхий 2-оос доошгүй ажил зохион байгуулсан байна.	
	3.1.13.Хөдөөний малчин айл өрхийг нүүхдээ буйраа цэвэрлэдэг уламжлалт зан заншлыг сэргээж, зун, намрын нутагласан газрынхаа хог хаягдлыг цэвэрлэх тодорхой ажил зохион байгуулсан байх /Буйраа цэвэрлэх талаар гэрээ хэлцэл байгуулж ажиллах/	Тухай бүр	СЗДТГ, Багийн Засаг дарга	Малчин өрх	Үйл ажиллагаагаар	Эзэнгүй хог хаягдал багсаж, орчны бохирдол буурна.	
	3.2.1.Сумдад хатуу хог хаягдлыг цэвэрлэн зайлуулах ажлыг зохион байгуулах ажлын хэсэг томилох	IV/05-10	СЗДТГ	ААНБ	Үйл ажиллагаагаар	Ажлыг эзэнжүүлж, чанартай хийж гүйцэтгэнэ.	
3.2	Бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулах	IV/05-VI/25 IX/20-X/01	СЗДТГ, ААНБ	Иргэд	ОНТ		

		<p>3.2.3.Сэг зэмийг цэвэрлэж, устгах, халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулах</p> <p>3.2.4.Төв суурин газрын ойролцоох овоо тахилгын орчныг цэвэрлэж, тохижуулах</p> <p>3.2.5.Улсын болон орон нутгийн чанартай зам болон даваан дээрх овоо тахилгын орчны цэвэрлэх</p> <p>3.2.6.Хөдөөний багуудын айл өрхийн өвөлжөө, хаваржааны хог хаягдлыг цэвэрлэх</p> <p>3.2.7."Цэвэрхэн наадацгаая" уриан дор үндэсний баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхтэй холбогдуулан хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулах</p> <p>3.2.8.Үерийн далан, суваг шуудууг цэвэрлэх</p> <p>3.2.9.Сум, байгууллага бүр хийсэн ажлын тайлан мэдээг тоо баримт, фото зургаар баримтжуулан БОАЖГ-т ирүүлэх</p>	<p>IV/05-V/25</p> <p>IV/05-V/25</p> <p>IV/15-V/20 IX/25-X/01</p> <p>IV/15-V/25</p> <p>VI/25-VII/05, VII/15-VII/25</p> <p>VI/10-12</p> <p>VI/05-15 IX/25-X/15</p>	<p>МЭГ, СЗДТГ</p> <p>СЗДТГ</p> <p>СЗДТГ</p> <p>Багийн Засаг дарга</p> <p>СЗДТГ</p> <p>СЗДТГ</p> <p>БОАЖГ</p>	<p>ААНБ, Иргэд</p> <p>ААНБ, Иргэд</p> <p>ААНБ, Иргэд</p> <p>Айл өрх</p> <p>ТУА, ААНБ, иргэд</p> <p>ААНБ</p> <p>Сумын ЗДТГ</p>	<p>ОНТ</p> <p>ОНТ</p> <p>ОНТ</p> <p>Өөрийн хөрөнгө</p> <p>Үйл ажиллагаагаар</p> <p>ОНТ</p> <p>Үйл ажиллагаагаар</p>	<p>Хариуцлагын тогтолцоог сайжруулж хамтран ажиллана.</p> <p>Орчны бохирдол багасна.</p> <p>Байгальд хаягдах хог багасна.</p> <p>Аялагч, амрагч нарт хог хаягдлын талаар зөв дадал хэвшил эзэмшүүлнэ.</p>
3.3	<p>Аяллын хоггүй аймаг уриалга гарган хог хаягдлыг багасгах ажлыг зохион байгуулах</p>	<p>3.3.1.Аялал жуулчлал, амралтын газрууд хог хаягдлыг багасгах төлөвлөгөө гарган сумын ЗДТГ-аар батлуулан ажиллах</p> <p>3.3.2.Амралт, аялал жуулчлалын газрууд хог хаягдлаа түр хадгалах цэг байгуулж, дахин ашиглах хог хаягдлыг ангилах ялгах ажлыг эхлүүлэх</p> <p>3.3.3.Ангилсан хог хаягдлыг сумын төвийн ангилсан хог хаягдлыг хүлээн авах цэгт хүргэх</p> <p>3.3.4.Аялал жуулчлал, амралтын газрууд "Ирлээ, явлаа-Цэвэр" аян өрнүүлж, аялагч амрагчдад зориулсан сурталчилгааг хийх</p>	<p>Жилдээ</p> <p>Жилдээ</p> <p>Жилдээ</p> <p>Жилдээ</p>	<p>ААНБ</p> <p>ААНБ</p> <p>ААНБ</p> <p>ААНБ</p>	<p>СЗДТГ</p> <p>СЗДТГ</p> <p>СЗДТГ</p> <p>СЗДТГ</p>	<p>Үйл ажиллагаагаар</p> <p>Үйл ажиллагаагаар</p> <p>Үйл ажиллагаагаар</p> <p>Үйл ажиллагаагаар</p>	<p>Хариуцлагын тогтолцоог сайжруулж хамтран ажиллана.</p> <p>Орчны бохирдол багасна.</p> <p>Байгальд хаягдах хог багасна.</p> <p>Аялагч, амрагч нарт хог хаягдлын талаар зөв дадал хэвшил эзэмшүүлнэ.</p>

3.4	Аюултай хог хаягдлын талаар	3.3.5.Аялал жуулчлал дагасан хог хаягдлын судалгааг гаргаж, цэвэрлэгээний ажлыг аяллын улиралд 3 удаа зохион байгуулах	V/20-V/25 VII/20-25 IX/20-25	СЗДТГ, БААЖХ	ААНБ, иргэд	ОНТ, Хувийн хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр	Аялал жуулчлал дагасан хог хаягдлыг цэвэрлэж, рашаан, голын голдирул болон байгальд хаясан хог хаягдал багасч орчны бохирдол доройтол буурна.
3.4	Аюултай хог хаягдлын талаар	3.2.6.Хог хаягдлаа тогтсон хугацаанд тээвэрлэх ажлыг хэвшүүлэх	7-10 хоног тутам	ААНБ	СЗДТГ	Үйл ажиллагаагаар	Орчны бохирдол доройтол багасна.
3.4	Аюултай хог хаягдлын талаар	3.4.1.Сумандаа байгаа Аюултай хог хаягдал, аюултай хог хаягдал үүсгэгчийн судалгааг гарган бүртгэлжүүлэх	I-II улирал	СЗДТГ	ААНБ	Үйл ажиллагаагаар	Аюултай хог хаягдал үүсгэгчийн бүртгэл мэдээллийн сантай болно.
3.4	Аюултай хог хаягдлын талаар	3.4.2.Аюултай хог хаягдлын түр хадгалах агуулах барих	Жилдээ	БОАЖЯ, ААНБ	АЗДТГ, БОАЖГ	УТ-365.0	Аюултай хог хаягдлын хадгалах агуулах баригдсан байна.
3.5	“Жорлонгоо өөрчилъе” аян, нүхэн жорлонг ариутган халдваргүйжүүлэх	3.5.1.Булган сумын гэр хорооллын өрхийн нүхэн жорлонг соруулдаг 00 болгох /100 айл өрхийг хамруулах/	Жилдээ	БОАЖГ	ААНБ	БХС-210.0	Нүхэн жорлонг соруулдаг 00 болгосноор хөрс, ус, агаарын бохирдол багасна.
3.5	“Жорлонгоо өөрчилъе” аян, нүхэн жорлонг ариутган халдваргүйжүүлэх	3.5.2.Аялал жуулчлал, рашаан, амралтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг ААНБ-ын нүхэн жорлонг байгальд эзлтэй боловсон жорлон болгох	V-VII сар	СЗДТГ	ААНБ	ААНБ өөрийн хөрөнгөөр	Хөрс, усны бохирдол багасна.
3.6	Сумдад хог ачих автомашин нийлүүлэх	3.5.3.Сум бүр айл өрх, албан байгууллагын нүхэн жорлонг ариутган халдваргүйжүүлэх ажлыг зохион байгуулах	IV-VI сар	СЗДТГ, ЭМТ	Багийн Засаг дарга, айл өрх	Үйл ажиллагаагаар	Орчны бохирдол буурч, эргүүл аюулгүй орчин бүрдэнэ.
3.6	Сумдад хог ачих автомашин нийлүүлэх	3.6.1.Хог ачих зориулалтын тоноглогдсон авто машиныг 6 суманд нийлүүлнэ.	I-VI сар	БОАЖГ	ААНБ	ОНТ	Булган, Хишиг-Өндөр, Хутаг-Өндөр, Могод, Бугат, Дашинчигэн сум хог ачих автомашинтай болно.

	3.6.2.Хог хаягдал тээвэрлэх автомашиныг 4 суманд нийлүүлнэ.	I-VI сар	БОАЖГ	ААНБ	БХС	Баян-Агт, Гурванбулаг, Тэшиг сум, Хялганат тосгон хог ачих автомашинтай болно.
--	---	----------	-------	------	-----	--

002
Аймгийн Засаг даргын 2022 оны
сарын 10. -ны өдрийн 1/20 дүгээр
захирамжийн 3 дугаар хавсралт

**“ЦЭВЭР ОРЧИН-ЦЭМЦГЭР БУЛГАН” АЯНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХАД
ШААРДАГДАХ ЗАРДЛЫН ТООЦОО**

№	Үйл ажиллагаа	Тоо хэмжээ	Зардал (Төг)	Төсөв (Төг)
1	“Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аяныг зохион байгуулах (16 сум 1 тосгон)	17	1 500 000	25 500 000
2	Аяныг хамгийн сайн зохион байгуулсан сум шалгаруулах уралдаан шагнал	3	2 800 000	2 800 000
3	“Цэвэр орчин-Цэмцгэр Булган” аян, Аялал жуулчлалын жил, Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хэрэгжүүлсэн ажлыг дүгнэх	Ажлын хэсэг	Шатахуун, томилолт	2 700 000
4	“Цэвэр орчин-Цэмцгэр Булган аян”, Аялал жуулчлалын жил, Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг чиглэлээр сургалт, сурталчилгааг зохион байгуулах /төрийн албан хаагчид, ААНБ-ын дарга, багийн Засаг дага нарыг хамруулна/	16 сум, 1 тосгон	Шатахуун, томилолт, бусад зардал	3 000 000
Нийт				34 000 000